



ЭДИЙН ЗАСАГ,  
ХӨГЖЛИЙН ЯАМ

---

# ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, 2023 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ, БОДЛОГЫН ЧИГЛЭЛ

САЙД Ч.ХҮРЭЛБААТАР

2022 оны 10 дугаар сар

## АГУУЛГА

---

- I. Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал
- II. Эдийн засгийн 2023 оны төсөөлөл
- III. Болзошгүй эрсдэлийн тойм
- IV. Тэргүүлэх бодлогын чиглэл



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР


ЭДИЙН ЗАСАГ,  
ХӨГЖЛИЙН ЯАМ

# I. ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ



# ӨСӨЛТ СААРЧ, ИНФЛЯЦ ӨСӨЖ, АЖИЛ ЭРХЛЭЛТ БУУРАВ. (СТАГФЛЯЦ).

### Эдийн засгийн өсөлт бодитой нэмэгдээгүй.




улирлаар

Эдийн засгийн өсөлт 2017-2019 онуудад дунджаар **6.3 хувь** байсан бол 2022 оны эхний хагас жилд өсөлт **1.9\*** хувь гарлаа. Үүнээс ХАА-н өсөлтийн суурийн нөлөөг хасвал **0.1 хувь** байна.

\*ҮСХ-ны сарын ДНБ-ий өсөлт тооцох туршилтын тооцоогоор эхний 8 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар өссөн.

### Инфляц зорилтот түвшнээс даваад байна.



улирлаар

Цар тахлаас өмнө импортын барааны инфляц нийт инфляцын **30 орчим хувийг** бүрдүүлдэг байсан бол 2022 оны 9 дүгээр сарын байдлаар **56 хувийг** бүрдүүлж байна.

### Ажиллах хүчний оролцоо бодитой нэмэгдээгүй.




улирлаар

2020 оны сүүлээс огцом буурсан ажиллах хүчний оролцоо сүүлийн улирлуудад сэргэж эхэлсэн ч цар тахлын өмнөх түвшинд хүрээгүй байна.




ГОЛ САЛБАРУУДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ БУУРАХ ХАНДЛАГАТАЙ БАЙНА.


Уул уурхай




Тээвэр




Барилга




Худалдаа



Боловсруулах




Хөдөө аж ахуй





ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮДИЙН ЭКСПОРТ ЦАР ТАХЛЫН ӨМНӨХ ТҮВШИНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.


Нүүрс, сая.тн




Зэсийн баяжмал, мян.тн



Алт, тн




Газрын тос, мян.баррель



Төмрийн хүдэр, мян.тн



Жонш, мян.тн






# ВАЛЮТЫН НӨӨЦ БУУРЧ, ТӨГРӨГИЙН ХАНШ ОГЦОМ СУЛАРЧ БАЙНА.

### Төлбөрийн тэнцэл


сая ам.доллар



Төлбөрийн тэнцлийн алдагдал 1.5 тэрбум ам.долларт хүрч 2013 оноос хойших хамгийн өндөр түвшинд хүрлээ.

### Гадаад валютын нөөц


сая ам.доллар



Гадаад валютын нөөц оны эхнээс 1.6 тэрбум ам.доллараар буурч, 2.8 тэрбум ам.долларт хүрлээ. (2022 оны 9 дүгээр сарын байдлаар)

### Ханш

Ам.доллартой харьцах төгрөгийн албан ханш (сарын дундаж)



Албан, албан бус ханшийн зөрүү



Төгрөгийн ханш 3,370 төгрөг болж, оны эхнээс 521 төгрөгөөр буюу 18 хувиар сулраад байна. (2022.10.14-ний өдрийн байдлаар)

Арилжааны банкны ханшийг Голомт, ХХБ, Хаан банкнуудын бэлэн зарах ханшийн дунджаар, Найман шаргын ханшийг Уран уургач, Евро Ази байгууллагуудын дунджаар авав.



**БНХАУ-ын Ганцмод боомтод бүртгэгдэж (SXCoal) байгаа нүүрсний гэрээний үнэ болон ЭТТ ХК-ийн борлуулалтын үнэ нилээд их зөрүүтэй байна.**

/тонн, ам.доллар/

|  | 2020             | 2021            | 2022.Q1         | 2022.Q2         | 2022.Q3         |
|--|------------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|
| <b>Ганцмод боомт үнэ /Хятад талд бүртгэгдсэн үнэ, SXCoal/*</b> | <b>\$ 125.9</b>  | <b>\$ 264.3</b> | <b>\$ 333.1</b> | <b>\$ 334.9</b> | <b>\$ 236.6</b> |
| БНХАУ - НӨАТ (13%)   | 14.6             | 30.4            | 38.3            | 38.1            | 27.2            |
| БНХАУ - Хилийн хураамж, агуулахын зардал                       | 4.7              | 6.3             | 7.0             | 6.8             | 5.8             |
| БНХАУ - Импортын татвар (3%)                                   | 3.2              | 6.8             | 8.6             | 0.0             | 0.0             |
| Монгол - Цагаанхад-Ганцмод чиглэлийн тээврийн зардал           | 28.8             | 103.9           | 99.9            | 121.8           | 33.3            |
| Монгол - Цагаанхадны зардал                                    | 1.5              | 1.6             | 1.6             | 1.5             | 1.4             |
| Монгол - Цагаанхад-Уурхай чиглэлийн тээврийн зардал            | 10.0             | 14.0            | 14.2            | 13.5            | 13.0            |
| Монгол - Тээврийн болон талбайн хорогдол (3%)                  | 1.9              | 3.0             | 4.9             | 4.5             | 4.7             |
| <b>Нийт хасагдах зардал /ам.доллар/</b>                        | <b>64.7</b>      | <b>166</b>      | <b>174.5</b>    | <b>186.2</b>    | <b>58.4</b>     |
| <b>Нийт хасагдах зардал /%/</b>                                | <b>51%</b>       | <b>63%</b>      | <b>52%</b>      | <b>56%</b>      | <b>25%</b>      |
| Гашуунсухайт - Ганцмод хүртэлх нийт зардал (БНХАУ)             | 18%              | 16%             | 16%             | 13%             | 14%             |
| Гашуунсухайт боомт хүртэлх нийт зардал (Монгол)                | 34%              | 46%             | 36%             | 42%             | 22%             |
| <b>Уурхайн ам нөхцөлөөр зарах боломжит дээд үнэ</b>            | <b>61.2</b>      | <b>98.3</b>     | <b>158.6</b>    | <b>148.7</b>    | <b>151.2</b>    |
| <b>ЭТТ ХК-ий борлуулалт</b>                                    | <b>2020</b>      | <b>2021</b>     | <b>2022.Q3</b>  |                 |                 |
| Уурхайн ам нөхцөлөөр (FCA) зарсан дундаж үнэ                   | 42.8             | 55.7            | 127.5           |                 |                 |
| <b>Тонн тутамд үүсэж байгаа үнийн зөрүү</b>                    | <b>18.4</b>      | <b>42.5</b>     | <b>23.7</b>     |                 |                 |
| Хилээр гарсан нүүрсний хэмжээ /сая тонн/                       | 8.75             | 6.11            | 6.73            |                 |                 |
| <b>Экспортын алдагдсан боломж /сая ам.доллар/</b>              | <b>\$ 151.74</b> | <b>\$ 259.7</b> | <b>\$ 159.6</b> |                 |                 |

Гаалийн жишиг үнэ бодох аргачлал

**ЭТТ ХК-ийн 2022 оны экспортын мэдээний зөрүү**

- 2022 оны нийт экспортын орлого /жишиг үнэ/: **1.86 тэрбум \$**
  - Монголбанканд тушаасан: **507.2 сая \$**
- ЗӨРҮҮ: 1,374.0 сая \$**


**Зөрүү үүссэн шалтгаан:**



Оффтейк болон нүүрсээр төлбөр барагдуулах гэрээ



Бүртгэлийн зөрүү /жишиг үнэ/



Өмнөх онуудад борлуулсан нүүрсний экспорт




Борлуулсан болон зах зээлийн бодит үнийн зөрүү



# МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ, ЗЭЭЛ БУУРЧ БАЙНА.

Мөнгөний нийлүүлэлт буурч эхэлж байна.

Мөнгөний нийлүүлэлт  
(тэрбум төгрөг)




улирлаар

Мөнгөний нийлүүлэлт 2020 оны эхнээс 2021 оны дунд хүртэл 37 хувь буюу **8 их наяд** төгрөгөөр өссөн бол түүнээс хойш тогтворжиж **26.9 их наяд төгрөгт** хүрээд байна.

Зээлийн жилийн өсөлтийн дийлэнхийг хэрэглээ болон худалдааны салбарын зээл бүрдүүлсэн байна.

Зээлийн үлдэгдлийн жилийн өөрчлөлт  
(хувь)




улирлаар

Арилжааны банкнуудын зээлийн үлдэгдэл 2022 оны 8 дугаар сарын байдлаар **22.6 их наяд төгрөгт** хүрч, өмнөх оны мөн үеэс **14.6 хувиар өссөн** байна. Өсөлтийн дийлэнхийг худалдаа, хэрэглээний зээл бүрдүүлсэн байна.

Зээлийн үлдэгдэл сүүлийн 2 сар буурлаа.

Зээлийн үлдэгдэл  
(тэрбум төгрөг)




сараар

Арилжааны банкнуудын зээлийн үлдэгдэл 2022 оны 7, 8 дугаар сард өмнөх сараас **0.6 болон 2.4 хувиар** тус тус буураад байна.




# ӨРХҮҮДИЙН БОДИТ ОРЛОГО БУУРЧ, ХАДГАЛАМЖААСАА ХЭРЭГЛЭЭНД ЗАРЦУУЛЖ БАЙНА.

### Өрхийн хэрэглээний жилийн өсөлт нэмэгдсэн (хувь)




2022 оны эхний хагас жилийн байдлаар өрхийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс **6.9 хувиар**, цар тахлын өмнөх түвшнээс **3.3 хувиар** нэмэгдсэн.

### Өрхийн бодит орлогын жилийн өсөлт буурсан (хувь)



2022 оны эхний хагас жилийн байдлаар өрхийн бодит мөнгөн орлого өмнөх оны мөн үеэс **0.8 хувиар** буурлаа.

### Иргэдийн хадгаламж буурсан (их наяд төгрөг)




Иргэдийн хадгаламж 14.8 их наяд болж, оны эхнээс **1.6 их наядаар (9.6%)**, өмнөх оны мөн үеэс **1.8 их наядаар (11.0%)** тус тус буурсан байна.



ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ҮНЭТ ЦААСНЫ ҮНЭ УНАЖ, ӨГӨӨЖИЙН ТҮВШИН ӨСӨЖ БАЙНА.


|   |              | Гаргасан дүн | Хүү    | Гаргасан он | Дуусах он | Үлдэгдэл дүн |
|---|--------------|--------------|--------|-------------|-----------|--------------|
| 1 | Чингис       | \$ 1,000 сая | 5.125% | 2012        | 2022      | \$ 137 сая   |
| 2 | Гэрэгэ       | \$ 800 сая   | 5.625% | 2017        | 2023      | \$ 533 сая   |
| 3 | Хуралдай     | \$ 600 сая   | 8.75%  | 2017        | 2024      | \$ 600 сая   |
| 4 | Номад        | \$ 600 сая   | 5.125% | 2020        | 2026      | \$ 600 сая   |
| 5 | Сенчири 2027 | \$ 500 сая   | 3.5%   | 2021        | 2027      | \$ 500 сая   |
| 6 | Сенчири 2031 | \$ 500 сая   | 4.45%  | 2021        | 2031      | \$ 500 сая   |

Бондуудын өгөөжийн түвшин




Эх үүсвэр: Блүүмберг терминал

ЗГ-ын гадаад үнэт цаасны үнэ унаж, өгөөжийн түвшин өсөж байгаа нь цаашид өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд арилжаалах гадаад үнэт цаасны хүү өндөр тогтох эрсдэлийг бий болгож байна.



## ЭНЭ УДААГИЙН ХЯМРАЛ НЬ ӨМНӨХ ХЯМРАЛУУДААС ИЛҮҮ ГҮНЗГИЙ БӨГӨӨД УДААН ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.



- Эдийн засгийн нийт үйлдвэрлэл (ДНБ) нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар боломжит хүчин чадлаасаа **3.9 хувиар бага** байна.
- COVID-19-ын үеийн хямрал нь өмнөх хямралуудаас **удаан** үргэлжилж байна.

## ДҮГНЭЛТ – 2022 ОН

- ▶ Өсөлт саарч, инфляц өсөж, ажил эрхлэлт буурснаар стагфляцын нөхцөл бүрдсэн байна.
- ▶ Гол салбаруудын үйлдвэрлэл буурах хандлагатай байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээл болон ААН-үүдийн сэргэлтэд сөргөөр нөлөөлж байна. **Мөн валютын гүйлгээний хязгаарлалтын улмаас импортын орцоос өндөр хамааралтай салбарууд болон нийтлэг ААН-үүдийн үйл ажиллагаа эрс хумигдаж, зогсох эрсдэлтэй байна.**
- ▶ Төлбөрийн тэнцлийн алдагдал **1.5 тэрбум ам.доллар** болж, 2013 оноос хойших хамгийн өндөр түвшинд хүрснээр, **гадаад валютын албан нөөц эрчимтэй буурч, төгрөгийн ханш огцом суларч байна.**
- ▶ ЗГ-ын гадаад үнэт цаасны **үнэ унаж** байгаа нь ойрын хугацаанд өрийн менежментийн хүрээнд гаргах гадаад **үнэт цаасны хүү өндөр тогтох** эрсдэлийг бий болгож байна.
- ▶ Зээл олголт удааширсан, зээлийн үлдэгдэл буурсан. Өрхүүдийн бодит орлого сэргээгүй байгаа нь нийт эрэлтийг хязгаарлаж байна.
- ▶ Цар тахлын үеийн хямрал нь өмнөх хямралуудаас илүү гүнзгий бөгөөд удаан үргэлжилж байна.



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

ЭДИЙН ЗАСАГ,  
ХӨГЖЛИЙН ЯАМ


## II. 2023 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ

# ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ БУУРАХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА.

**Зэсийн үнэ (\$/тонн)**



**Коксжих нүүрсний үнэ (\$/тонн)**



**ЭРЭЛТ БУУРНА** - Дэлхийн улсуудын бодлогын хүү өсөж, эдийн засаг удаашрах, улмаар түүхий эдийн нийт эрэлт буурна.

**Зэс** – Дэлхийн зарим томоохон зэсийн уурхайнуудын (Перу, Чили улсуудын) үйл ажиллагаа цар тахлаас хойш хэвийн болж, нийлүүлэлт өсөх төлөвтэй.

**Коксжих нүүрс** – Экспортлогч орнуудын ажиллах хүч нэмэгдэж, нийлүүлэлт өснө. Эрэлт буурах төлөвтэй.

**Төмрийн хүдэр** - Ажиллах хүчний хомсдол, байгалийн гамшгаас үүдсэн нийлүүлэлтийн саатал тогтворжиж, нийлүүлэлт өсөх төлөвтэй.

**Брент газрын тосны үнэ** – Дэлхийн эдийн засгийн удаашрал, БНХАУ-ын хямралаас үүдэж эрэлт буурах төлөвтэй.

**Төмрийн хүдрийн үнэ (62% агууламжтай, \$/тонн)**



**Брент газрын тосны үнэ (\$/баррель)**



Эх үүсвэр: Блүүмберг терминал

Эх үүсвэр: Дэлхийн банк, Түүхий эдийн зах зээлийн төлөв байдлын тайлан  
Олон улсын эрчим хүчний агентлаг

# ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛНЭ.

## 2023 онд

Уул уурхайн салбарыг **цар тахлын өмнөх** хэмжээнд хүргэнэ.

**Төсөв, мөнгөний бодлогоо чангаруулснаар** эдийн засаг тогтворжино.

Эдийн засгийг **төрөлжүүлнэ.** (хүнсний үйлдвэрлэл, аялал жуулчлал, хөнгөн үйлдвэрлэл)

**Хөгжлийн хязгаарлагч салбаруудын либералчлалыг** хэрэгжүүлж, эдийн засгийг дэмжинэ. (эрчим хүч, тээврийн салбар)

### ДНБ-ий өсөлт

2017-2019

6.3%

2020

-4.6%

2021

1.6%

2022

2.6%

2023

3.5%

МУУ ХУВИЛБАР


БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ

5.0%

Экспорт болон хувийн хэвшлийг дэмжиж, бодлогын арга хэмжээ хэрэгжүүлснээр



# ИНФЛЯЦ ЗОРИЛТОТ ТҮВШНЭЭС ӨНДӨР БАЙХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА.



Эх үүсвэр: ЭЗХЯ-ны тооцоолол, (ҮСХ-ны статистик)

## 2023 онд

Төлбөрийн тэнцлийн дарамт өндөр байгаа нь **төгрөгийн ханшийг сулруулж**, үнийн өсөлтөд хүчтэй нөлөөлөх эрсдэлтэй байна.

БНХАУ-ын хилийн хязгаарлалтын улмаас **ачаа, эргэлт удаашрах** эрсдэл хэвээр байна.

Украинд болж буй дайн үргэлжлэх эрсдэл

Худалдааны түнш орнуудын инфляц 2023 оны эхний хагас жилд өндөр байж, **импортоос шалтгаалсан** инфляцын дарамт үргэлжилнэ.

Эрчим хүч болон тээврийн үнийн өсөлт

## ТӨСӨӨЛӨЛ – 2023 ОН

- ▶ Улс орнуудын төв банкууд бодлогын хүүгээ нэмэгдүүлж байгаа нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг сааруулж, **түүхий эдийн эрэлт буурах** төлөвтэй байна. Түүнчлэн экспортлогч улсуудын ажиллах хүчин нэмэгдэж, цар тахлын нөхцөл байдал сайжирснаар түүхий эдийн нийлүүлэлт нэмэгдэж, үнэ буурах нөхцөл бүрдэхээр байна.
- ▶ Түүхий эдийн үнэ буурах хандлага нь манай экспортын орлогод сөргөөр нөлөөлнө. Мөн гадаад инфляцын нөлөөгөөр импортын бараа, үйлчилгээнд төлөгдөх **валютын гадагшлах урсгал нэмэгдэх, ашигт малтмалын эскпортын зохистой тогтолцоо нэвтрүүлэхгүй бол** төлбөрийн тэнцэл, валютын нөөцийн одоогийн байдлыг **улам муутгах** эрсдэлтэй байна.
- ▶ Өрхийн **бодит орлого сэргэж эхлээгүй** байгаа нь нийт эрэлтэд сөргөөр нөлөөлөхөөр байна. Гол салбаруудын үйлдвэрлэл, үйл ажиллагааны **сэргэлт удаан** байх төлөвтэй. Цар тахал дахин идэвхжих, хилийн боомтын үйл ажиллагаа хязгаарлагдмал байх зэрэг эдийн засгийн үйл ажиллагаа хумигдах эрсдэлүүд хэвээр байна.
- ▶ Валютын ханш, худалдааны түнш орнууд дахь өндөр инфляц, тээвэр зохион байгуулалтын доголдол зэргээс шалтгаалан **инфляц төв банкны зорилтот түвшнээс өндөр** хэвээр байх эрсдэлтэй байна.

# III. БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ТОЙМ

1

## УКРАЙНД БОЛЖ БУЙ ДАЙН

- ОХУ, Европоос импортолдог стратегийн бүтээгдэхүүний төлбөр тооцоо, нийлүүлэлт тасалдах
- Импортын бүтээгдэхүүнүүдийн үнэ өсөх, үйлдвэрлэлийн зардал нэмэгдэх
- Тээврийн логистикийн доголдол үүсэх

2

## МӨНГӨНИЙ ХАТУУ БОДЛОГООС ШАЛТГААЛСАН ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН СААРАЛТ

- Өрийн менежмент хийх, бонд гаргах, арилжааны зээл авахад хүү өндөр тогтох
- Дэлхийн эдийн засгийн сэргэлт удаашрах
- Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн эрэлт болон үнэ буурах

3

## САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭМЗЭГ БАЙДАЛ

- Банкны салбар цөөн хэдэн банкнаас өндөр хамааралтай учир аливаа эрсдэл тохиолдоход санхүүгийн системийн хэмжээнд тогтвортой байдал алдагдах
- Банкнуудын активын чанарын үнэлгээ хангалтгүй үнэлэгдэж, нээлттэй хувьцаат компани болоход хүндрэл учирсан тохиолдолд санхүүгийн салбарт тодорхойгүй байдал үүсгэх

4

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАНГАМЖ

- Шаардагдах ачааллаа хангахгүй доголдох, гэмтэл гарах, нийлүүлэлтийн тасалдалд хүргэх
- Улмаар бодит салбаруудын үйл ажиллагааг хязгаарлах, нийт эдийн засгийн бүтээмжид сөргөөр нөлөөлөх

5

## ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН ХҮНДРЭЛ

- Стратегийн бүтээгдэхүүний тээвэрлэлт саатаж, бодит салбаруудын үйлдвэрлэлийн орц тасалдах
- Хувийн хэвшлийн зардлыг нэмэгдүүлэх
- Инфляцын дарамт нэмэгдэх,
- Урт хугацаанд эдийн засгийн нийт бүтээмж буурах

6

## МАЛЫН ӨВЧИН, ЦАГ АГААР, ГАН ЗУДЫН ЭРСДЭЛ

- ХАА-н салбарын үйлдвэрлэл, бүтээмж буурах
- Хүнсний инфляцын дарамт нэмэгдэх
- Өрхүүдийн бодит орлого буурах, тэгш бус байдал нэмэгдэх

7

## ЦАР ТАХЛЫН ЭРСДЭЛ

- Дэлхий дахинд цар тахал дахин идэвхэжсэнээр тээвэр, логистик, боомтын үйл ажиллагаа доголдох
- Дотоодод халдварын тохиолдол нэмэгдвэл эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаа хумигдах, нийт эрэлт саарах

8

## ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ БУУРАХ БОЛОН АЛИВАА ТӨРЛИЙН ХОРИГ

- Өрийн менежмент хийх, бонд гаргах, арилжааны зээл авахад хүү өндөр тогтох
- Олон улсын төлбөр тооцоо саатах
- Гадаадын хөрөнгө оруулалт буурах



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

ЭДИЙН ЗАСАГ,  
ХӨГЖЛИЙН ЯАМ

# IV. 2023 ОНД ТЭРГҮҮЛЭХ БОДЛОГЫН ЧИГЛЭЛ

## Энэ ондоо эхлүүлж, ирэх оны эхний улиралд бодитой хэрэгжүүлж ажил хэрэг болгох, улмаар үр нөлөө нь 2023 оны сүүлийн хагас жилийн эдийн засгийн үзүүлэлтэд эерэг нөлөө үзүүлэх бодлогын арга хэмжээнүүд

1

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

- Төсөв, мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж эдийн засгийг тогтворжуулна.
- Валютын бодит мөнгөн орлогыг нэмэгдүүлэх багц арга хэмжээг авч хэрэгжүүлснээр валютын албан нөөцийг нэмэгдүүлэх.

2

### ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭГ ЦАР ТАХЛЫН ӨМНӨХ ТҮВШИНД ХҮРГЭЖ НЭМЭГДҮҮЛНЭ.

- Экспортын гэрээнүүд болон олборлолтоос экспорт хүртэлх бүх шатны борлуулалтыг цахимжуулж, бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлнэ;
- Уурхайн ам нөхцөлөөр борлуулахыг зогсоож, хил хүртэлх нөхцөлөөр (С зөвшөөрлийг олборлогч ААН олгох) цаашид борлуулах;

3

### УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИЛ ТОД БОЛГОНО.

- Түүхий эдийн борлуулалт, гэрээнүүдийг ил тод болгож далд эдийн засгийг бууруулах
- Уул уурхайн компаниудын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг ил тод болгож хяналтын зөв тогтолцоог бий болгох

4

### УУЛ УУРХАЙ, ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОЛОВСРУУЛАЛТЫН ТҮВШНИЙГ НЭГ ШАТ АХИУЛНА.

- Газрын тос боловсруулах үйлдвэр
- Махны экспортыг үргэлжлүүлж нэмэгдүүлэх
- Арьс шир боловсруулах үйлдвэр ашиглалтад орох хүртэл түүхий эдийн экспортыг эхлүүлэх

5

### ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙГ ХЯЗГААРЛАЖ БУЙ САЛБАРУУДАД ЛИБЕРАЛЧЛАЛ ХЭРЭГЖҮҮЛНЭ.

- Эрчим хүчний салбарыг үе шаттай либералчлах
- Тээврийн салбарыг (төмөр зам, агаарын тээвэр) либералчлах
- Банкны салбарын реформ, өрсөлдөөнийг дэмжих

6

### ХУВИЙН ХЭВШИЛ, БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИНЭ.

- Эдийн засгийг төрөлжүүлэх (хүнсний үйлдвэрлэл, аялал жуулчлал, хөнгөн үйлдвэрлэл)
- Хөрөнгө оруулалтыг дэмжих
- Төрийн хүнд суртлыг бууруулах (төрийн тусгай зөвшөөрлийн цахим систем г.м)

7

### САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨРЛИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.

- Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх (ХК-ын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох, хариуцлагыг нэмэгдүүлэх)
- Даатгалын тогтолцоог бэхжүүлэх (ил тод, найдвартай даатгалын тогтолцоог бий болгох)

8

### БООМТ, ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛНА.

- Нийт боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх
- 2023 онд Гашуунсухайт боомтод төмөр замын чингэлэг терминал
- Ачаа болон зорчигч тээврийн барилга байгууламж байгуулах
- Шивээхүрэн боомтод чингэлэг тээврийн терминал байгуулах,

## МАКРО ТОГТВОРТОЙ ОРЧНЫГ ДЭМЖСЭН ТӨСӨВ, МӨНГӨНИЙ БОДЛОГО



### ЗАСГИЙН ГАЗАР: ТӨСВИЙН БОДЛОГО

**1** 2023 ОНЫ ТӨСӨВТ **ШИНЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** НЭМЭХГҮЙ.

**2** ТӨСВИЙН **АЛДАГДЛЫГ ДНБ-ИЙ 2.8 ХУВЬ ХҮРТЭЛ** БУУРУУЛАХ.

**3** ВАЛЮТЫН БОДИТ МӨНГӨН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БАГЦ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР **ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦИЙГ** НЭМЭГДҮҮЛЭХ.



### МОНГОЛБАНК: МӨНГӨНИЙ БОДЛОГО

**1** МӨНГӨНИЙ **ХАТУУ БОДЛОГО** ХЭРЭГЖҮҮЛЭХ.

**2** ВАЛЮТЫН НӨӨЦ, ХАНШИЙГ ОНОВЧТОЙ ТОХИРУУЛАХ.

**3** МОНГОЛБАНК **ТӨСВИЙН ШИНЖТЭЙ** ҮЙЛ АЖИЛЛАГАА САНХҮҮЖҮҮЛЭХИЙГ ЗОГСООХ.

**4** **БАНКНЫ САЛБАРЫН РЕФОРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ ӨРСӨЛДӨӨНИЙГ** НЭМЭГДҮҮЛЭХ.

Төсөв, мөнгөний бодлогын хүрээнд улсын **зээлжих зэрэглэл буурах** болон **аливаа хоригт орох** эрсдэлээс сэргийлсэн бодлогын тохируулгуудыг тухай бүрд авч хэрэгжүүлэх.

**ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭГ ЦАР ТАХЛЫН ӨМНӨХ ТҮВШИНД ХҮРГЭХ, ОЛБОРЛОЛТ ТЭЭВЭРЛЭЛТ БОРЛУУЛАЛТЫГ САЙЖРУУЛЖ ЭКСПОРТЫН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ.**

| Бүтээгдэхүүн   | НЭГЖ    | 2019  | 2020  | 2021  | 2022.08 | 2022* | 2023* |
|----------------|---------|-------|-------|-------|---------|-------|-------|
| ЧУЛУУН НҮҮРС   | сая.тн  | 36.5  | 28.6  | 15.7  | 14.8    | 24.0  | 36.5  |
| ЗЭСИЙН БАЯЖМАЛ | мян.тн  | 1,398 | 1,391 | 1,270 | 977     | 1,275 | 1,398 |
| АЛТ            | тн      | 9.1   | 30.5  | 17.2  | 8.6     | 17.0  | 17.0  |
| ГАЗРЫН ТОС     | мян.бар | 6,538 | 4,071 | 4,349 | 949     | 2,220 | 6,538 |
| ТӨМРИЙН ХҮДЭР  | мян.тн  | 8,421 | 8,202 | 7,002 | 2,656   | 5,120 | 8,421 |

Эх үүсвэр: ЭЗХЯ-ны тооцоолол, (ҮСХ-ны статистик)

**Хэрэгжүүлэх арга хэмжээний санал:**

Уурхайн ам нөхцөлөөр борлуулахыг зогсоож, **хил хүртэлх нөхцөлөөр (С зөвшөөрлийг олборлогч ААН олгох)** цаашид борлуулах;

Экспортын гэрээнүүд болон олборлолтоос экспорт хүртэлх бүх шатны борлуулалтыг **цахимжуулж, бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлнэ;**

Түүхий эдийн борлуулалтыг **уул уурхайн биржээр дамжуулан зах зээлийн ил тод тогтолцоонд шилжүүлэх.**

## 2022 ОНД БАГТААН 1.8 ТЭРБУМ ХҮРТЭЛ АМ.ДОЛЛАРЫН БОДИТ ВАЛЮТЫН ОРЛОГО ОРУУЛНА .

Хүчин төгөлдөр гэрээ, хэлцлүүдийн хүрээнд экспорт, тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулж (*оффтейк болон урьдчилж борлуулсан гэрээний нүүрсний ачилтыг бууруулах*), валютын орлого оруулах (*Б.Ганхуяг, Г.Ёндон, Б.Мөнхбат, А.Ариунболд*)

**500 сая ам.доллар**  
*“Эрдэнэс Тавантолгой” ХК*



**300 сая ам.доллар**  
*“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ*



**20 сая ам.доллар**  
*“Монголросцветмет” нэгдэл*



**15 сая ам.доллар**  
*“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨҮГ*



Уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг компаниудтай валютын орох урсгал, нөөцийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах (*УУХҮ-ийн сайд Ж.Ганбаатар, Сангийн сайд Б.Жавхлан*)



**БУСАД**  
**экспортлогч**  
**ААН-үүд**

**1 тэрбум ам.доллар хүртэл**



## “Уурхайн амны үнэ” нөхцөл

ЭСВЭЛ


## “Хилийн үнэ” нөхцөл

Одоогийн дийлэнх гэрээнүүдийн нөхцөл

ЭТТ ХК **\$71**  
нэгжийн үнэ (1 тонн)\*

Тээврийн компаниуд **\$58**  
нэгжийн үнэ (1 тонн)\*

- ЭТТ ХК зөвхөн тээвэрлэлтээс өмнөх орлогыг хүлээн авч, валютын орлогыг Монголбанканд арилжаалдаг. (\$411 сая, эхний 8 сар)
- Уурхайн амнаас хил хүртэлх тээврийн зардлыг худалдан авагч талаас тээврийн компаниудад төлдөг. (\$338 сая, эхний 8 сар)



Тээврийн С зөвшөөрлийг  
уурхайн компаниудад олгох

ЭТТ ХК **\$129** (\$71 + \$58)  
нэгжийн үнэ (1 тонн)\*


- ЭТТ ХК хил хүртэлх орлогыг валютаар хүлээн авна.
- ЭТТ ХК нь тээврийн компаниудын төлбөрийг төгрөгөөр төлнө.

Ингэснээр

- ЭТТ-н гадаад валютын орлого нэмэгдэнэ.
- Монголбанкны валютын орлого, нөөц нэмэгдэнэ.

## Ашигт малтмалын экспортод гарахаас өмнөх цахим төлбөрийн бүртгэл, экспортод гаргахад шинжилгээний дүгнэлт, гаалийн бүрдүүлэлтийн автомат тогтолцоо

### Экспортод гарахаас өмнөх үе



Гарал үүсэл,  
дотоодын борлуулалт

Гаалийн хялбаршуулсан  
цахим бүрдүүлэлт

#### Экспортод гарахаас өмнөх үеийн цахим төлбөрийн баримтын хяналт

1. Цахим төлбөрийн баримтаар дотоодын борлуулалтыг бүртгэлжүүлж гарал үүслийг тодорхойлох.
2. Худалдах, худалдан авах, тээвэрлэх бүх гэрээг цахим хэлбэрт шилжүүлэх.

### Экспортод гарах үе



Автомат лабораторийн  
дээж авагч

Ачаа тээврийн  
хяналт

Татварын автомат  
тооцоолол

#### Экспортод гаргах үеийн гаалийн бүрдүүлэлтийг автоматжуулалтын үе шат

1. Боомтууд дээр лабораторийн шинжилгээг хийх, дүгнэлтийг нарийн тодорхойлох тоног төхөөрөмжүүдийг нэвтрүүлэх
2. Гаалийн бүрдүүлэлтийг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх, дугаар таних, автомат хаалт, жин хэмжих тоног төхөөрөмжүүдийг автоматжуулж хүний оролцоогүй болгох.



# БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОЛОВСРУУЛАЛТЫН ТҮВШНИЙГ АХИУЛЖ, ЭКСПОРТЫН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ.

Экспортын бүтэц, боловсруулалтын түвшнээр, 2019 он

## ТҮҮХИЙ ЭД 90.2%

|                       |                                |                              |                    |                           |                      |
|-----------------------|--------------------------------|------------------------------|--------------------|---------------------------|----------------------|
| <b>44.9%</b><br>Нүүрс | <b>26.2%</b><br>Зэсийн баяжмал | <b>8.4%</b><br>Төмрийн хүдэр | <b>6.1%</b><br>Алт | <b>5.4%</b><br>Газрын тос | <b>9.0%</b><br>Бусад |
|-----------------------|--------------------------------|------------------------------|--------------------|---------------------------|----------------------|

## ХАГАС БОЛОВСРУУЛСАН 7.2%

|                               |                     |                             |                                     |                         |                      |
|-------------------------------|---------------------|-----------------------------|-------------------------------------|-------------------------|----------------------|
| <b>56.4%</b><br>Ноос, ноолуур | <b>24.4%</b><br>Мах | <b>11.2%</b><br>Катодын зэс | <b>4.3%</b><br>Хүнсний бүтээгдэхүүн | <b>2.5%</b><br>Арьс шир | <b>1.2%</b><br>Бусад |
|-------------------------------|---------------------|-----------------------------|-------------------------------------|-------------------------|----------------------|

## БОЛОВСРУУЛСАН 0.8%

|                               |                                     |                     |
|-------------------------------|-------------------------------------|---------------------|
| <b>95.9%</b><br>Нэхмэл хувцас | <b>2.3%</b><br>Хүнсний бүтээгдэхүүн | <b>1.8%</b><br>Хивс |
|-------------------------------|-------------------------------------|---------------------|

## PE-ЭКСПОРТ 1.8%

|                                 |                                      |                                     |                      |
|---------------------------------|--------------------------------------|-------------------------------------|----------------------|
| <b>83.5%</b><br>Тоног төхөөрөмж | <b>6.4%</b><br>Төмөрлөг бүтээгдэхүүн | <b>4.3%</b><br>Хүнсний бүтээгдэхүүн | <b>5.8%</b><br>Бусад |
|---------------------------------|--------------------------------------|-------------------------------------|----------------------|

Боловсруулалтын түвшнийг ахиулах боломж:

### УУЛ УУРХАЙН САЛБАР



#### Газрын тос

- Газрын тос боловсруулах үйлдвэр
- Дамжуулах хоолой



#### Зэсийн баяжмал

Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр



#### Төмрийн хүдэр

Дарханы гангийн үйлдвэр



#### Нүүрс

Угаах, баяжуулах үйлдвэр

### ХАА-Н САЛБАР



#### Арьс шир

Техникийн зохицуулалт дээр тохируулгад өөрчлөлт оруулж боловсруулах үйлдвэр ашиглалтад орох хүртэл экспортыг эхлүүлэх.



#### Мах

Махны экспортыг үргэлжлүүлж нэмэгдүүлэх. Махны үйлдвэрийн төслүүдийг хөдөлгөх

## ХӨГЖЛИЙН ХЯЗГААРЛАГЧ САЛБАРУУДЫН ЛИБЕРАЛЧЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ.

 **ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ****ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ЛИБЕРАЛЧЛАЛЫГ ҮЕ ШАТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

Цахилгаан, дулааны зохистой хэрэглээг дэмжсэн, хэрэглэгчид хэрэглээндээ өөрсдөө тохируулга хийх сонголтыг олгосон үнэ тариф, төлбөрийн ил тод, ухаалаг, шударга, зөв тогтолцоог бүрдүүлэх.

**Эрчим хүчний системийн нөхцөл байдал:**

- Цахилгаан дамжуулалтын алдагдал өндөр
  - Цахилгааны **шугамын алдагдал 15%**
  - Дулааны станцуудын **насжилт 35-60 жил**
- Түгээх шугамын
  - 50-аас дээш хувь нь **35-аас дээш жил**
  - 30 гаруй хувь нь **15 жилийн өмнө** суурилагдсан.
- Цахилгаан тасалдлын **дундаж хугацаа 62 цаг** (Казакстан 0.96 цаг), **тасалдлын давтамж 15** (Казакстан 1.7) байна.\*

**ТЭЭВРИЙН САЛБАРТ****ТЭЭВРИЙН САЛБАРЫН ЛИБЕРАЛЧЛАХ**

Төмөр зам, агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлэх, тээвэр зохион байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах, тээврийн логистикийн нэгдсэн цахим платформ бүрдүүлж хувийн хэвшилд мэдээллийг нээлттэй болгох, иргэд, аж ахуйн нэгжүүд төлөвлөлтөө хийх боломж олгох.

**Төмөр замын нөхцөл байдал:**

- УБТЗ-д ашиглаж байгаа 1,537 км төмөр замын **51 хувь** нь **30-50 жилийн** насжилттай төмөр зам байна.
- Төмөр замд гарч байгаа хурц гэмтлийн **90 гаруй хувь** нь энэ төмөр зам дээр тохиолдож байна. Түүнчлэн зүтгүүр, вагоны ихэнх нь **ашиглалтаас гарах** төлөвтэй байна.

**БАНКНЫ САЛБАРТ****I. БАНКНУУДЫГ НЭЭЛТТЭЙ ХК БОЛГОХ ШИНЭЧЛЭЛИЙГ ДУУСГАХ.**

AQR үнэлгээг дуусгаж, **ойрын хугацаанд ил тод болгох.**

**II. ГАДААДЫН БАНК МОНГОЛ УЛСАД САЛБАРАА НЭЭХ Ү/А-Г ХЯЛБАРШУУЛЖ, ЗӨВ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ ЭХЛҮҮЛЭХ.**


Гадаадын банкны салбар МУ-д үйл ажиллагаа явуулах тухай **Монголбанкны журмын шаардлагыг хялбаршуулах.**

**Одоогийн журам:**

- Төлөөлөгчийн газар нь МУ-д **дор хаяж 1 жил ү/ажиллагаа явуулсан** байх
- Бусад улсад 3-аас дээш жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх
- **Топ-100 банкны нэг байх**


## ХУВИЙН ХЭВШЛИЙН САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ.

Санхүүгийн салбар дахь банкны салбарын эзлэх хувь




Эх үүсвэр: Монголбанк, СЗХ

Хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн тоо



Эх үүсвэр: СЗХ

Санхүүгийн салбарын бүтэц:



Эх үүсвэр: Монголбанк, СЗХ



### Хөрөнгийн зах зээлийн салбарт:

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН Ү/А-Г ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БОЛГОЖ ХАРИУЦЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ:

- Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжиж, **олон улсын жишигт нийцсэн нарийн зохицуулалтыг** яаралтай бий болгох (оролцогчдын эрх ашгийг хамгаалсан, ил тод, хариуцлагатай, тогтвортой)
- Компаниудын **хувьцаа гаргах үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох**
- Хувьцаа эзэмшигчийн **эрх ашгийг хамгаалах** зохицуулалтыг сайжруулах.



### Даатгалын салбарт:

ИЛ ТОД, НАЙДВАРТАЙ ДААТГАЛЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ.

- Хувийн хэвшлийн санхүүжилтийг дэмжсэн даатгалын тогтолцоог бий бүрдүүлж бэхжүүлнэ.
- Даатгалын салбарын хөрөнгийн удирдлагын менежментийг сайжруулах бодлогын дэмжлэг үзүүлнэ.

## 2023 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛД БАГТААН ЭДИЙН ЗАСГИЙГ ТОГТВОРЖУУЛНА.

| Үзүүлэлт                   | Хэмжих<br>нэгж     | 2019   | 2020   | 2021   | 2022*  | 2023*  |
|----------------------------|--------------------|--------|--------|--------|--------|--------|
| <b>Эдийн засгийн өсөлт</b> | <i>хувь</i>        | 5.6    | -4.6   | 1.6    | 2.6    | 5.0    |
| Уул уурхайн                | <i>хувь</i>        | -1.6   | -9.9   | 0.8    | -11.0  | 14.6   |
| Уул уурхайн бус            | <i>хувь</i>        | 6.9    | -3.7   | 1.8    | 4.8    | 3.7    |
| <b>Инфляц</b>              | <i>хувь</i>        | 5.2    | 2.3    | 13.4   | 12.0   | 8.0    |
| <b>Нийт экспорт</b>        | <i>сая ам.дол.</i> | 7,620  | 7,576  | 9,247  | 10,711 | 11,106 |
| <b>Нийт импорт</b>         | <i>сая ам.дол.</i> | 6,127  | 5,294  | 6,849  | 8,320  | 9,035  |
| Худалдааны эргэлт          | <i>сая ам.дол.</i> | 13,748 | 12,870 | 16,096 | 19,031 | 20,141 |
| Худалдааны тэнцэл          | <i>сая ам.дол.</i> | 1,493  | 2,282  | 2,399  | 2,391  | 2,071  |



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

ЭДИЙН ЗАСАГ,  
ХӨГЖЛИЙН ЯАМ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД  
БАЯРЛАЛАА.